



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/033/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Баянхонгор хот  
2026.02.25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат  
Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Алтантуяа  
Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn  
Аудитор: А.Адилзаяа  
Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно. ....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Албан шаардлага.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.26 № 2/21  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т  
Г \_\_\_\_\_ Г

БӨӨН ЦАГААН-ОРОГ НУУРЫН САВ  
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА  
Б.НЯМ-ОЧИР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бөөнцагаан орог-Нуурын сав газрын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлын онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант онд байгууллагын хоол, унааны хөнгөлөлтөд улсын төсвөөс 29,484.5 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 29,460.9 мянган төгрөг зарцуулсан байна. Дээрх хөнгөлөлтийн тарифыг 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцэн баталсан байгууллагын дотоод журмын 6.7.1-т нэг өдөрт ногдох өдрийн тарифыг 20.0 мянган төгрөгөөс 34.5 мянган төгрөг байхаар тогтоосон байна.

6426050107

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-  
албан тоот.docx

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тайлант онд батлагдсан төсөвт тодотгол хийж, зардлын дүнг бууруулснаас 2,842.8 мянган төгрөгийн байгууллагад төлөх өр төлбөр үүссэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд нийт 47 ажил төлөвлөснөөс хэрэгжилтийн хувь 92.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>14,219,754.85</b>	<b>28,688,329.25</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	73,824.64	14,145,529.25
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	73,824.64	49,615.25
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	14,095,914.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	9,145,930.21	9,542,800.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	5,586,380.00	5,586,380.00
35110	Тусгай зориулалттай материал	5,586,380.00	5,586,380.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	3,559,550.21	3,956,420.00
35410	Бичиг хэргийн материал	285,120.00	484,420.00
35420	Аж ахуйн материал	3,208,000.00	3,472,000.00
35440	Түлш, шатах тослох материал	66,430.21	-
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	5,000,000.00	5,000,000.00
36100	Барааны нөөц	5,000,000.00	5,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>310,783,510.67</b>	<b>311,161,300.22</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	310,783,510.67	311,161,300.22
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	291,515,577.34	292,146,953.53
39203	Авто-тээврийн хэрэгсэл	342,062,996.50	340,364,996.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(81,340,349.40)	(113,697,665.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,745,657.52	84,753,247.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,264,015.04)	(19,470,339.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,934,740.39	9,934,740.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,623,452.63)	(9,738,025.63)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	19,267,933.33	19,014,346.69
39301	Програм хангамж	1,267,933.33	1,267,933.33
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(253,586.64)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,000,000.00	18,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>325,003,265.52</b>	<b>339,849,629.47</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>2,842,810.42</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	2,842,810.42
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	2,842,810.42
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,074,960.42
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	330,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	437,850.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	437,850.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>325,003,265.52</b>	<b>337,006,819.05</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	325,003,265.52	337,006,819.05
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	325,003,265.52	337,006,819.05
51210	Өмнөх үеийн үр дүн	325,003,265.52	325,003,265.52
51220	Тайлант үеийн үр дүн	-	12,003,553.53
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>325,003,265.52</b>	<b>339,849,629.47</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>567,632,742.03</b>	<b>495,297,024.50</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,485,754.53</b>	<b>40,630,262.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	17,485,754.53	40,630,262.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,485,754.53	40,630,262.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	17,055,945.43	40,608,590.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	429,809.10	21,672.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>550,146,987.50</b>	<b>454,666,762.50</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	386,309,500.00	385,378,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	386,309,500.00	385,378,700.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	163,837,487.50	69,288,062.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,295,251.50	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,781,000.00	68,938,062.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,761,236.00	350,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>583,531,547.75</b>	<b>483,293,470.97</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>583,531,547.75</b>	<b>483,293,470.97</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	527,307,068.04	472,189,710.61
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	289,914,248.30	302,108,380.68
210101	Үндсэн цалин	178,733,286.30	166,684,938.50
210102	Нэмэгдэл	59,611,362.00	83,082,059.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,897,000.00	29,460,886.00
210104	Урамшуулал	25,672,600.00	22,880,497.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	35,219,408.48	37,227,396.27
210201	Тэтгэврийн даатгал	24,328,900.87	25,818,820.40
210202	Тэтгэмжийн даатгал	2,875,055.89	2,918,547.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,546,592.54	1,744,181.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,293,771.21	1,357,136.53
210205	Эрүүл мэндийн даатгал	5,175,087.97	5,388,709.54
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	19,468,800.00	22,744,800.00
210304	Байрны түрээс	19,468,800.00	22,744,800.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,274,558.86	24,167,553.21
210401	Бичиг хэрэг	6,795,280.00	3,577,780.00
210402	Тээвэр, шатахуун	18,519,378.86	17,996,374.21
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,774,550.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	325,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,863,900.00	445,089.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	48,760.00
210408	Бараа материал акталсны зардал	116,000.00	-
2105	<b>Нормативт зардал</b>	1,469,600.00	-

Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,469,600.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	55,000.00	6,944,694.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	55,000.00	331,995.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	3,830,299.00
210604	Урсгал засвар	-	2,782,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,798,000.00	3,557,600.00
210702	Дотоод албан томилолт	3,798,000.00	3,557,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	107,377,710.60	29,601,486.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,347,614.00	29,176,814.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	122,300.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	94,950.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	703,446.60	360,322.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	6,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	102,900.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	38,729,741.80	45,837,800.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,208,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,729,741.80	44,629,800.45
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	56,224,479.71	11,103,760.36
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	32,749,600.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,709,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,040,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	23,474,879.71	10,689,113.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,474,879.71	10,689,113.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	414,647.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	414,647.36
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(15,898,805.72)</b>	<b>12,003,553.53</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(15,898,805.72)</b>	<b>12,003,553.53</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>550,146,987.50</b>	<b>442,566,762.50</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>550,146,987.50</b>	<b>442,566,762.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	386,309,500.00	385,378,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	386,309,500.00	385,378,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	163,837,487.50	57,188,062.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,295,251.50	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,781,000.00	56,838,062.50

Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,761,236.00	350,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>538,978,751.40</b>	<b>438,167,762.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>538,978,751.40</b>	<b>438,167,762.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>482,754,271.69</b>	<b>425,068,088.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>286,033,631.57</b>	<b>301,071,045.33</b>
210101	Үндсэн цалин	154,931,800.00	165,647,603.15
210102	Нэмэгдэл	82,869,563.50	83,082,059.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,927,218.07	29,460,886.00
210104	Урамшуулал	25,305,050.00	22,880,497.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>34,317,129.62</b>	<b>36,165,561.81</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,875,377.08	24,756,985.94
210202	Тэтгэмжийн даатгал	2,756,733.97	2,918,547.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,469,200.00	1,744,181.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,251,940.29	1,357,136.53
210205	Эрүүл мэндийн даатгал	4,963,878.28	5,388,709.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,468,800.00</b>	<b>22,744,800.00</b>
210304	Байрны түрээс	19,468,800.00	22,744,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,679,800.00</b>	<b>7,041,629.00</b>
210401	Бичиг хэрэг	1,839,600.00	1,478,240.00
210402	Тээвэр, шатахуун	3,260,200.00	3,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,444,550.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	325,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	493,839.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>-</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>153,200.00</b>	<b>7,208,694.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	153,200.00	357,294.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	4,069,000.00
210604	Урсгал засвар	-	2,782,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,798,000.00</b>	<b>3,557,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,798,000.00	3,557,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>129,303,710.50</b>	<b>47,278,758.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,273,613.90	46,404,086.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	122,300.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	94,950.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	703,446.60	360,322.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	6,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	102,900.00	450,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,224,479.71</b>	<b>13,099,674.36</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>32,749,600.00</b>	<b>-</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,709,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,040,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>23,474,879.71</b>	<b>10,689,113.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,474,879.71	10,689,113.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>2,410,561.36</b>

Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,410,561.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,168,236.10	4,399,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,400,000.00	4,399,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,400,000.00	4,399,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,400,000.00	4,399,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,400,000.00	4,399,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(9,400,000.00)	(4,399,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,768,236.10	(0.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/	
					Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	342,670,307.44		342,670,307.44
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	342,670,307.44	-	342,670,307.44
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(17,667,041.92)		(17,667,041.92)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	325,003,265.52	-	325,003,265.52
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	325,003,265.52	-	325,003,265.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	325,003,265.52	-	325,003,265.52
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	12,003,553.53		12,003,553.53
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	337,006,819.05	-	337,006,819.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	429,903,300.0	385,378,700.0	44,524,600.0	89.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	429,903,300.0	385,378,700.0	44,524,600.0	89.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	429,903,300.0	385,378,700.0	44,524,600.0	89.6
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	429,902,300.0	374,689,587.0	55,212,713.0	87.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	429,902,300.0	374,689,587.0	55,212,713.0	87.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	389,750,000.0	374,689,587.0	15,060,413.0	96.1

Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	300,810,200.0	292,697,630.2	8,112,569.8	97.3
210101	Үндсэн цалин	165,526,100.0	165,647,603.2	-121,503.2	100.1
210102	Нэмэгдэл	78,051,500.0	74,708,644.0	3,342,856.0	95.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,484,500.0	29,460,886.0	23,614.0	
210104	Урамшуулал	27,748,100.0	22,880,497.0	4,867,603.0	82.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,142,400.0	36,165,561.8	1,976,838.2	94.8
210201	Тэтгэврийн даатгал	25,945,600.0	24,756,985.9	1,188,614.1	95.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,052,300.0	2,918,547.9	133,752.1	95.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,535,700.0	1,744,181.9	-208,481.9	113.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,523,100.0	1,357,136.5	165,963.5	89.1
210205	Эрүүл мэндийн даатгал	6,085,700.0	5,388,709.5	696,990.5	88.5
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23,343,500.0	22,744,800.0	598,700.0	97.4
210304	Байрны түрээс	23,343,500.0	22,744,800.0	598,700.0	97.4
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,769,300.0	7,041,629.0	2,727,671.0	72.1
210401	Бичиг хэрэг	1,845,700.0	1,478,240.0	367,460.0	80.1
210402	Тээвэр, шатахуун	3,300,000.0	3,300,000.0	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,081,800.0	1,444,550.0	1,637,250.0	46.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	860,100.0	325,000.0	535,100.0	37.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	681,700.0	493,839.0	187,861.0	72.4
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	220,000.0	0.0	220,000.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	220,000.0	0.0	220,000.0	0.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,875,500.0	11,607,694.0	267,806.0	97.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,756,300.0	4,756,294.0	6.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,336,800.0	4,069,000.0	267,800.0	93.8
210604	Урсгал засвар	2,782,400.0	2,782,400.0	0.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,557,600.0	3,557,600.0	0.0	100.0
210702	Дотоод албан томилолт	3,557,600.0	3,557,600.0	0.0	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,031,500.0	874,672.0	1,156,828.0	43.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.0	0.0	224,000.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	289,700.0	64,350.0	225,350.0	22.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	561,000.0	360,322.0	200,678.0	64.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,900.0	0.0	60,900.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	895,900.0	450,000.0	445,900.0	50.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	40,152,300.0	0.0	40,152,300.0	0.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	40,152,300.0	0.0	40,152,300.0	0.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,152,300.0	0.0	40,152,300.0	0.0
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	11	10	1	90.9
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1	0	1	0.0

## 2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөгөөр/
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>54,777,501.14</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>54,777,501.14</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	54,777,501.14
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	8,373,415.14
210102	Нэмэгдэл	8,373,415.14
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	46,404,086.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,404,086.00
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,410,561.36</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,410,561.36
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	57,188,062.50
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	57,188,062.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	56,838,062.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	350,000.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргаа нь сав газрын хэмжээнд усны нөөцийг хомсдол бохирдлоос хамгаалах, боломжит нөөцийг зүй зохистой ашиглах, орон нутгийн салбар дундын зохицуулалтыг хангах “Усны менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод аудит/аудиторын чиг үүргийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хэрэгжүүлдэг ба тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2025 оны санхүүгийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,846.4 мянган төгрөг буюу 1.05 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	73.8	14,145.5	14,071.7
Бараа материал	9,145.9	9,542.8	396.8
Нөөцийн бараа	5,000.0	5,000.0	-
Үндсэн хөрөнгө	310,783.5	311,161.3	377.8
Хуримтлагдсан элэгдэл	(100,227.8)	(143,159.6)	(42,931.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>325,003.3</b>	<b>339,849.6</b>	<b>14,846.4</b>
Өр төлбөр	-	2,842.8	2,842.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	325,003.3	337,006.8	12,003.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>325,003.3</b>	<b>339,849.6</b>	<b>14,846.4</b>

Авлагын дансны үлдэгдэл 14,071.7 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн авлага 14,095.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 33.0 мянган төгрөг, цалингийн авлага 16.5 мянган төгрөгийн үлдэгдэл нөлөөлсөн байна.

Тайлант онд 29,368.5 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр, 21.7 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч дансны үнийг нэмэгдүүлж, 28,993.3 мянган төгрөгийн бараа материалыг албан хэрэгцээнд зарцуулсан байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 311,161.3 мянган төгрөг болж оны эхний үлдэгдэл хөрөнгөөс 377.8 мянган төгрөгөөр өссөн нь БОУАӨЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/364 тоот тушаалаар БОАЖЯ-аас Баянхонгор аймгийн Бөөн цагаан-Орог нуурын сав газарт үнэ төлбөргүй шилжүүлэн ирсэн 40,608.6 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4,399.0 мянган төгрөг, нийт 45,007.6 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийг нэмэгдүүлж, ТӨБЗГ-ын 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 407 дугаар албан бичгийг үндэслэн 1,698.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг акталж, 143,159.6 мянган төгрөгийн тайлант оны хуримтлагдсан элэгдэл үндсэн хөрөнгийн дүнг бууруулахад голлох нөлөөг үзүүлсэн байна.

Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй 1,267.9 мянган төгрөгийн өртөг бүхий Си ти эс ХХК-ийн "Си ти эс" программыг урсгал зардлын төсвөөс 450.0 мянган төгрөгөөр ашиглах эрх худалдан авч, өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тайлант онд өглөгийн дансны үлдэгдэл 2,842.8 мянган төгрөг болж нэмэгдсэн нь 12 дугаар сард төсвийн тодотгол хийж зардлын дүнг бууруулснаас байгууллагад төлөх өглөг 767.8 мянга, гүйлгээг хязгаарласны улмаас ХХОАТ-ын өглөг 2,075.0 мянган төгрөгийг өглөг үүссэн байна. Дээрх өглөгийг дараагийн аудитаар анхаарах хэсэгт оруулсан болно.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 475,372.8 мянган төгрөгөөр тооцож дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд төсвийг 58,502.8 мянган төгрөгөөр тодотгож, оны эхэнд 416,870.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 389,598.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 385,378.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үүнээс урсгал үйл ажиллагаанд 374,689.6 мянган төгрөгийг зарцуулж, 10,689.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 374,689.6 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 87.2 хувийг зарцуулсан байгаа нь байгууллагын 2025 оны төсөвт батлагдсан тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 40,152.3 мянган төгрөгийг олгоогүйтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>71404 Усны нөөц, нуур, гол мөрний менежмент</b>					
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	389,750,000.0	374,840,787.0	14,909,213.0	96.2
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	40,152,300.0	-	40,152,300.0	-
3	81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	-	-	-	-

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Баянхонгор аймгийн Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргаа нь БОАЖС-ын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/158, 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/335 дугаар тушаалыг тус тус үндэслэн газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар байгууллагын бүтцийг 11 орон тоотойгоор баталж, гүйцэтгэлээр 9 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулсан бөгөөд БОУАӨС-ын даргын 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/685 дугаар “Сав газрын захиргааны бүтэц, орон тооны дээд хязгаар болон байршлыг шинэчлэн тогтоох тухай” тушаалаар орон тоог 9 хувиар буюу гүйцэтгэх 1 орон тоог бууруулан 10 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар баталсан байна.

Тайлант онд байгууллагын хоол, унааны хөнгөлөлтөд улсын төсвөөс 29,484.5 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 29,460.9 мянган төгрөг зарцуулсан байна. Дээрх хөнгөлөлтийн тарифыг 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцэн баталсан байгууллагын дотоод журмын 6.7.1-т нэг өдөрт ногдох өдрийн тарифыг 20.0 мянган төгрөгөөс 34.5 мянган төгрөг байхаар тогтоосон байна.

### 3.5.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант хугацаанд аймгийн Засаг даргын захирамжаар усны хамгаалалт, тоо бүртгэл, хяналттай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэхэд аймгийн Байгаль орчны газраас 48,400.0 мянган төгрөг, орон нутгаас албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдэл 8,438.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 350.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, гүйцэтгэлээр 54,777.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,410.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв /улсын төсөв/ болох 429,902.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар букуу 4,299.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Аудитыг төлөвлөх үе шатанд тус байгууллагад хамаарах Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой 54 эрсдэлийг сонгож бүртгэсэн бөгөөд, аудитаар зөрчил илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад 5 саяас дээш дүнтэй орлогын 120,214.0 мянган төгрөгийн 5 гүйлгээ, байгууллагын үндсэн мэдээлэл хэсэгт нягтлан бодогчийн мэдээллийг ил тод байршуулаагүй тул нөхөн мэдээлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын байгууллагын аудитор Г.Энхзул гүйцэтгэсэн бөгөөд аудитаар 73.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, тайлант хугацаанд бүрэн биелсэн байна.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	73.8	1	73.8	100
Нийт дүн	1	73.8	1	73.8	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн хуваарилалт, өр төлбөрийн удирдлагад эрсдэл үүсэх магадлалтай байгаа тул өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажилласан байдал, төсвийн тодотгол хийх үеийн өр төлбөрийн тооцоонд анхаарч, дараагийн аудитаар давтагдсан эсэхийг үзэх шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,100.0 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

Тайлант онд аймгийн Засаг даргын захирамжаар хэрэгжүүлсэн 4 арга хэмжээний хүрээнд 60,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг аймгийн Байгаль орчны газраас авахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 48,400.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үлдэгдэл санхүүжилтийн авлагыг 12,500.0 мянган төгрөгөөр тусгасан буюу 400.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтад нийцэхгүй байна

Аудитаар нийт 120,214.0 мянган төгрөгийн 1 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 120,214.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

5.1.1 Баянхонгор аймгийн Бөөн цагаан-Орог нуурын сав газрын шилэн дансны нэгдсэн цахим системд байгууллагын үндсэн мэдээлэл хэсэгт нягтлан бодогчийн мэдээлэл оруулаагүй, цалингийн зардлаас бусад 120,214.0 мянган төгрөгийн орлогын 5 гүйлгээг гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэснийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансанд нөхөж мэдээлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудаст байгууллагын үндсэн мэдээлэлд нягтлан бодогчийн мэдээлэл оруулаагүй, цалингийн зардлаас бусад 120,214.0 мянган төгрөгийн орлогын 5 гүйлгээг гүйлгээг мэдээлээгүй байна.	1	120,214.00			1	120,214.00			
Дүн	1	120,214.00			1	120,214.00			

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oO-----